



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 1/91

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 118.222.281 (Нэг зуун арван найман сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун наян нэгэн) төгрөгийн санхүүжилтээр хийгдэж буй "Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж, тохижилт"-ын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Гишүүд: Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Б.Баярмаа (ЗДТГ-ын нярав)

А.Адъяа (Иргэний төлөөлөл)

Ж.Наранцэцэг (Иргэний төлөөлөл)

2. Нийтийн биеийн тамирын талбай нь зураг төсвийн дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, шаардлагад нийцсэн байгууламжийг хүлээн авах, холбогдох акт баримтыг журмын дагуу үйлдэж, бүрдүүлэхийг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ